



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/681

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/104 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/104 дүгээр тушаалын дагуу Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээг тухай жилийн хагас, бүтэн жилээр үнэлж, үнэлгээний дүн, гэрээний талуудад өгөх зөвлөмжийг аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Батбилгүүн), гэрээний хэрэгжилтийг хангуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (М. Мөнх-Аюуш), гэрээнд тусгагдсан үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Аймгийн Засаг даргын 2022 оны А/136 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д даалгасугай.



ДАРГА

П. ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар
сарын 25-ны өдрийн А/с/д дугаар
захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

- Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүдэд:

- Нийгмийн Эрүүл мэндийн төвийн дарга
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн
дарга
- Эрүүл мэндийн удирдлагын хэлтсийн дарга
- Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл
мэндийн бодлого үйл ажиллагаа зохион
байгуулах мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Тархвар судлал
хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Мэдээ, мэдээлэл
хариуцсан мэргэжилтэн
- Өрхийн Анагаах Ухааны мэргэжилтнүүдийн
холбооны Хөвсгөл аймаг дах салбар
зөвлөлийн төлөөлөл
- Эрүүл мэндийн газрын Анхан шатны
тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн даргад: